

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Есөнзүйл сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: **ӨВА-2026/192/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Өвөрхангай аймаг,  
Арвайхээр сум

2026 он

Тэргүүлэх аудитор: О.Батжаргал

Утас: 70323253 Цахим хаяг: [Batjargalo@audit.gov.mn](mailto:Batjargalo@audit.gov.mn)

Аудитын менежер: П.Хорлоосүрэн

Утас: 70323108 Цахим хаяг: [Khorloosuren@audit.gov.mn](mailto:Khorloosuren@audit.gov.mn)

Ахлах аудитор: Б.Эрдэнэцэцэг

Утас: 70323108 Цахим хаяг: [Erdenetsetsegb@audit.gov.mn](mailto:Erdenetsetsegb@audit.gov.mn)

Чадварлаг Аудит ХХК-ийн захирал: Д.Рэнцэнханд

Утас: 99200034 Цахим хаяг: [chadvarlagAudit@gmail.com](mailto:chadvarlagAudit@gmail.com)

Аудитор: П.Байгальмаа

Утас: 99038857 Цахим хаяг: [Baigal0508@yahoo.com](mailto:Baigal0508@yahoo.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## 1.Хараат бус аудиторын дүгнэлт



### ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон, П.Гэндэнгийн гудамж,  
5 дугаар баг, Арвайхээр сум, Өвөрхангай аймаг, 62173,  
Утас/Факс: (976) 7032 3253,  
Цахим шуудан: uvurkhangai@audit.gov.mn,  
Цахим хуудас: www.audit.mn

Ауд. Он. 10 № 90  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Өвөрхангай аймгийн Есөнзүйл сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө / өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Өвөрхангай аймгийн Есөнзүйл сумын Эрүүл мэндийн төвийн санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд аж ахуйн аргаар барилга байгууламждаа засвар хийж, барилга байгууламжийн үнийн дүнг 35.3 сая төгрөгөөр нэмэгдүүлэн, эрүүл мэндийн яамнаас 3.5 сая төгрөгийн хөрөнгө оруулалт авч үндсэн хөрөнгөнд бүртгэсэн байна.

Жилийн эцсээр 85.9 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй байна. Тайлант онд 3 хөтөлбөр арга хэмжээнд 1,520.9 сая төгрөгийг зарцуулж зардлын гүйцэтгэл 82.9 хувьтай байна.

#### Аудитын гол асуудал

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлуудыг үздэг. Санхүүгийн тайланд хийсэн аудитын хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

Тайлант онд эрүүл мэндийн даатгалын сангаас 1,531.2 сая төгрөгийн, орон нутгийн төсвөөс 65.3 сая төгрөгийн санхүүжилт авч зарцуулсан байна. Орон нутгийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдэл 0.7 сая төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

6225020206

D:\Auditin gazar\baiguullagiin dotood barimt\A4

#### Бусад асуудал

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Тус байгууллага нь 2025 онд гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 9 зорилт төсөл, 44 арга хэмжээ төлөвлөж 95.0 хувийн биелэлттэй дүгнэгдсэн байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

#### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй. Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм. Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



О.БАТЖАРГАЛ

## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

ДАНС	ҮЗҮҮЛЭЛТ	ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>436,172,992.13</b>	<b>297,602,389.91</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	30,503,007.19	85,964,230.59
31211	Төрийн сангийн харилцах	30,503,007.19	85,964,230.59
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	341,251,575.90	163,397,983.70
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	1.21	-
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	341,251,574.69	163,397,983.70
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	64,418,409.04	48,240,175.62
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	38,587,301.98	16,142,407.62
35110	Тусгай зориулалттай материал	30,668,257.48	357,608.42
35130	Эм боох материал	7,919,044.50	15,784,799.20
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	25,831,107.06	32,097,768.00
35420	Аж ахуйн материал	1,688,498.00	509,500.00
35450	Барилгын засварын материал	100,000.00	-
35460	Хүнсний материал	1,860,888.00	3,042,840.00
35470	Бусад хангамжийн материал	22,181,721.06	28,545,428.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,033,465,376.73</b>	<b>1,217,014,327.85</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	1,033,465,376.73	1,217,014,327.85
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	1,016,459,876.85	1,200,166,327.97
39201	Барилга, байгууламж, орон сууц	928,235,803.44	963,535,803.44
39202	Хуримтлагдсан элэгдэл	(205,283,060.18)	(231,144,285.57)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	215,324,100.00	170,292,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(58,588,266.58)	(30,588,722.12)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	698,146,534.76	400,389,178.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(577,478,560.20)	(104,635,562.12)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	44,460,161.00	55,544,689.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(28,356,835.39)	(23,226,772.66)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	17,005,499.88	16,847,999.88
39301	Програм хангамж	2,090,000.00	2,090,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,402,500.12)	(1,560,000.12)
39303	Бусад биет бус хөрөнгө	16,318,000.00	16,318,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>1,469,638,368.86</b>	<b>1,514,616,717.76</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>24,722,576.72</b>	<b>52,966,310.00</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	24,722,576.72	52,966,310.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	24,722,576.72	52,966,310.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	47,786.72	-
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	16,774,790.00	52,966,310.00
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	7,900,000.00	-
41361	Байгууллагад төлөх өглөг	7,900,000.00	-
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,444,915,792.14</b>	<b>1,461,650,407.76</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	1,444,915,792.14	1,461,650,407.76
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	339,892,039.35	339,892,039.35
51101	Өмч: - төрийн	339,892,039.35	339,892,039.35
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	166,601,037.08	183,335,652.70
51210	Өмнөх үеийн үр дүн	166,601,037.08	166,601,037.08
51220	Тайлант үеийн үр дүн	-	16,734,615.62
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	938,422,715.71	938,422,715.71
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>1,469,638,368.86</b>	<b>1,514,616,717.76</b>

Өвөрхангай аймгийн Есөнзүйл сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны  
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

ДАНС	ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,710,491,115.90</b>	<b>1,418,676,259.90</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>274,737,193.00</b>	<b>222,449,285.00</b>
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого/үндсэн хөрөнгө/	274,737,193.00	222,274,285.00
12001	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого/Бараа материал/	18,792,405.62	10,996,356.78
120009	Бусад орлого	-	175,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,435,753,922.90</b>	<b>1,418,676,259.90</b>
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	59,956,600.00	65,335,000.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1,375,797,322.90	1,353,341,259.90
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,273,014,559.84</b>	<b>1,635,307,286.06</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,248,755,430.60	1,634,548,109.70
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	751,014,700.27	898,314,599.77
210101	Үндсэн цалин	408,768,689.87	433,414,702.00
210102	Нэмэгдэл	224,808,684.96	389,281,637.77
210103	Унаа хоолны хөнгөлөлт	27,280,166.00	24,970,600.00
210104	Урамшуулал	90,157,159.44	50,647,660.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	94,135,126.08	112,128,642.21
210201	Тэтгэврийн даатгал	58,398,226.08	77,202,565.05
210202	Тэтгэмжийн даатгал	12,291,900.00	8,914,721.10
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,907,500.00	4,998,737.88
210204	Ажилгүйдлийн даатгал	3,907,500.00	4,299,686.91
210205	Эрүүл мэндийн даатгал	15,630,000.00	16,712,931.27
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	49,619,976.38	51,475,823.64
210301	Гэрэл, цахилгаан	2,443,944.38	4,299,795.64
210302	Түлш, халаалт	47,176,032.00	47,176,028.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	50,168,995.00	91,917,512.37
210401	Бичиг хэрэг	5,370,400.00	4,066,900.00
210402	Тээвэр, шатахуун	30,112,200.00	39,000,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,965,400.00	1,895,400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	420,000.00	240,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,659,695.00	540,500.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	2,641,300.00	18,117,291.06
210408	Бараа материал акталсны зардал	-	28,057,421.31
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	188,569,728.08	289,879,897.83
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	168,342,121.28	259,233,449.83
210502	Хоол, хүнс	18,427,606.80	22,951,448.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,800,000.00	7,695,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	12,606,385.00	39,258,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	652,500.00	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	8,800.00	-
210604	Урсгал засвар	11,945,085.00	39,258,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	4,471,000.00	11,480,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	4,754,319.00	64,538,300.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	60,504,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	972,000.00	450,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	3,050,000.00	3,355,100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	145,156.00	144,100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.00	22,000.00
210807	Газрын төлбөр	63,663.00	63,100.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	468,500.00	-
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	93,415,200.79	75,555,333.88
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,444,815.00	6,750,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	89,970,385.79	68,805,333.88
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	5,466,723.62	759,176.36
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,466,723.62	759,176.36
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>437,476,556.06</b>	<b>(216,631,026.16)</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	1,762,130.95	80,000.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	1,394,287.48	-
225002	Найдваргүй авлагын алдагдал	367,843.47	80,000.00
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	(1,762,130.95)	(80,000.00)
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>473,299,236.35</b>	<b>16,734,615.62</b>

Өвөрхангай аймгийн Есөнзүйл сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

ДАНС	ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>1,126,226,799.21</b>	<b>1,596,704,850.89</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	-	<b>175,000.00</b>
120009	Бусад орлого	-	175,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,126,226,799.21</b>	<b>1,596,529,850.89</b>
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	59,956,600.00	65,335,000.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1,066,270,199.21	1,531,194,850.89
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>1,137,523,821.18</b>	<b>1,502,753,627.49</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,137,523,821.18</b>	<b>1,502,753,627.49</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,132,057,097.56</b>	<b>1,501,994,451.13</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	747,757,878.10	898,362,386.49
210101	Үндсэн цалин	375,581,902.17	433,462,488.72
210102	Нэмэгдэл	254,290,646.49	389,281,637.77
210103	Унаа хоолны хөнгөлөлт	18,197,000.00	24,970,600.00
210104	Урамшуулал	99,688,329.44	50,647,660.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	95,920,924.08	112,128,641.00
210201	Тэтгэврийн даатгал	64,660,924.08	77,202,563.84
210202	Тэтгэмжийн даатгал	7,815,000.00	8,914,721.10
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,907,500.00	4,998,737.88
210204	Ажилгүйдлийн даатгал	3,907,500.00	4,299,686.91
210205	Эрүүл мэндийн даатгал	15,630,000.00	16,712,931.27
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	49,619,976.38	51,475,823.64
210301	Гэрэл, цахилгаан	2,443,944.38	4,299,795.64
210302	Түлш, халаалт	47,176,032.00	47,176,028.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	41,759,300.00	64,913,900.00
210401	Бичиг хэрэг	2,970,000.00	2,970,000.00
210402	Тээвэр, шатахуун	28,099,400.00	39,000,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,895,400.00	1,895,400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	994,500.00	994,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,800,000.00	20,054,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	161,472,400.00	255,948,500.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	140,722,400.00	219,948,100.00
210502	Хоол, хүнс	17,000,000.00	21,750,400.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,750,000.00	14,250,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	18,922,900.00	35,300,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,853,000.00	
210604	Урсгал засвар	15,069,900.00	35,300,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	4,471,000.00	11,480,000.00
210702	Дотоод албан томилолт	4,471,000.00	11,480,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	5,382,719.00	65,635,200.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	60,504,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	972,000.00	450,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	3,050,000.00	3,355,100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	145,156.00	144,100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.00	22,000.00
210807	Газрын төлбөр	63,663.00	63,100.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,096,900.00	1,096,900.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	6,750,000.00	6,750,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,750,000.00	6,750,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>5,466,723.62</b>	<b>759,176.36</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,466,723.62	759,176.36
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>(11,297,021.97)</b>	<b>93,951,223.40</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>15,147,000.00</b>	<b>30,160,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>15,147,000.00</b>	<b>30,160,000.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	15,147,000.00	30,160,000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>(15,147,000.00)</b>	<b>(30,160,000.00)</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>(26,444,021.97)</b>	<b>63,791,223.40</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		<b>30,503,007.19</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>30,503,007.19</b>	<b>85,964,230.59</b>

Өвөрхангай аймгийн Есөнзүйл сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

2.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	339,892,039.35	938,422,715.71	(306,698,199.27)	971,616,555.79
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	339,892,039.35	938,422,715.71	(306,698,199.27)	971,616,555.79
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	473,299,236.35	473,299,236.35
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	339,892,039.35	938,422,715.71	166,601,037.08	1,444,915,792.14
D01	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	339,892,039.35	938,422,715.71	166,601,037.08	1,444,915,792.14
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	339,892,039.35	938,422,715.71	166,601,037.08	1,444,915,792.14
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	16,734,615.62	16,734,615.62
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	339,892,039.35	938,422,715.71	183,335,652.70	1,461,650,407.76

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ДАНС	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	ЗӨРҮҮ	ХУВЬ
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	1,835,459,402.00	1,520,984,451.13	314,474,950.87	82.9
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	1,835,459,402.00	1,520,984,451.13	314,474,950.87	82.9
210	<b>БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,835,459,402.00	1,520,984,451.13	314,474,950.87	82.9
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,132,072,100.00	898,362,386.49	233,709,713.51	79.4
210101	Үндсэн цалин	459,057,800.00	433,462,488.72	25,595,311.28	94.4
210102	Нэмэгдэл	528,648,700.00	389,281,637.77	139,367,062.23	73.6
210103	Унаа хоолны хөнгөлөлт	18,777,900.00	24,970,600.00	(6,192,700.00)	133.0
210104	Урамшуулал	125,587,700.00	50,647,660.00	74,940,040.00	40.3
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	141,203,600.00	112,128,641.00	29,074,959.00	79.4
210201	Тэтгэврийн даатгал	95,236,200.00	77,202,563.84	18,033,636.16	81.1
210202	Тэтгэмжийн даатгал	11,491,800.00	8,914,721.10	2,577,078.90	77.6
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,746,000.00	4,998,737.88	747,262.12	87.0
210204	Ажилгүйдлийн даатгал	5,746,000.00	4,299,686.91	1,446,313.09	74.8
210205	Эрүүл мэндийн даатгал	22,983,600.00	16,712,931.27	6,270,668.73	72.7
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	52,234,823.64	51,475,823.64	759,000.00	98.5
210301	Гэрэл, цахилгаан	5,058,795.64	4,299,795.64	759,000.00	85.0
210302	Түлш, халаалт	47,176,028.00	47,176,028.00	-	100.0
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	64,913,900.00	64,913,900.00	-	100.0
210401	Бичиг хэрэг	2,970,000.00	2,970,000.00	-	100.0
210402	Тээвэр, шатахуун	39,000,000.00	39,000,000.00	-	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,895,400.00	1,895,400.00	-	100.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутга	994,500.00	994,500.00	-	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	20,054,000.00	20,054,000.00	-	100.0
2105	<b>Нормативт зардал</b>	255,948,500.00	255,948,500.00	-	100.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	219,948,100.00	219,948,100.00	-	100.0
210502	Хоол, хүнс	21,750,400.00	21,750,400.00	-	100.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	14,250,000.00	14,250,000.00	-	100.0
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	73,799,900.00	54,290,000.00	19,509,900.00	73.6
210601	Багаж, техник, хэрэгсэл	18,999,900.00	18,990,000.00	9,900.00	99.9
210602	Тавилга	19,500,000.00	-	19,500,000.00	-
210604	Урсгал засвар	35,300,000.00	35,300,000.00	-	100.0
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	11,500,000.00	11,480,000.00	20,000.00	99.8
210702	Дотоод албан томилолт	11,500,000.00	11,480,000.00	20,000.00	99.8
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хура</b>	70,030,300.00	65,635,200.00	4,395,100.00	93.7
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний	60,504,000.00	60,504,000.00	-	100.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,000,000.00	450,000.00	1,550,000.00	22.5
210803	Даатгалын үйлчилгээ	6,155,100.00	3,355,100.00	2,800,000.00	54.5
210804	Тээврийн хэрэгслийн татвар	150,000.00	144,100.00	5,900.00	96.1
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	60,000.00	22,000.00	38,000.00	36.7
210807	Газрын төлбөр	64,300.00	63,100.00	1,200.00	98.1
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,096,900.00	1,096,900.00	-	100.0
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	46,750,000.00	6,750,000.00	40,000,000.00	14.4
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	46,750,000.00	6,750,000.00	40,000,000.00	14.4
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	-	1,596,529,850.89	(1,596,529,850.89)	
1320	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	-	65,335,000.00	(65,335,000.00)	
132001	Орон нутгийн төсвөөс	-	65,335,000.00	(65,335,000.00)	
1340	<b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	-	1,531,194,850.89	(1,531,194,850.89)	
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	-	1,531,194,850.89	(1,531,194,850.89)	
4	<b>Мөнгө, түүнтэй адилгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		<b>30,503,007.19</b>	<b>(30,503,007.19)</b>	
5	<b>Мөнгө, түүнтэй адилгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		<b>85,964,230.59</b>	<b>(85,964,230.59)</b>	

### 3. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 10,828.0 мянган төгрөгийн 1 алдаа зөрчил илэрснээс 10,828.0 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлсэн.

#### 3.1 Төлбөрийн акт

Тус байгууллага төлбөрийн акт бичигдээгүй.

#### 3.2 Албан шаардлага

1. Илрүүлэлт:

Эрүүл мэндийн төвийн даргын 2025 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн Б/19 тоот тушаалаар 5 эмч, эмнэлгийн мэргэжилтэнд 10,828.0 мянган төгрөгийн урамшууллыг улирлын үр дүнгийн урамшуулалтай давхардуулан олгосон байна

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 1.2.2-д "төсвийн шууд захирагч нь байгууллагын төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн үнэлгээ, улирлын ажлын үр дүнг үндэслэн холбогдох гүйцэтгэлийн үнэлгээний журамд тодорхойлсон мөнгөн урамшуулал авах нөхцөлийг хангасан төрийн албан хаагчид", 2.2-д "Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэлт:

Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллаж, биелэлтийг 2026 оны 06 дугаар сарын 01-ний дотор Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх албан шаардлага хүргүүлж байна.

#### 3.3 Зөвлөмж

Тус байгууллагад зөвлөмж өгөгдөөгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

### 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

#### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/				Зөвлөмж		
							Үүнээс						
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан	Залруулаагүй	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Дүн	00	00	000	00	00	00	00	00	00	00	00	0	0

Санхүүгийн тайлангийн аудитаар залруулга гараагүй.

Өвөрхангай аймгийн Есөнзүйл сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
Эрүүл мэндийн төвийн даргын 2025 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн Б/19 тоот тушаалаар 5 эмч, эмнэлгийн мэргэжилтэнд 10,828.0 мянган төгрөгийн урамшууллыг улирлын үр дүнгийн урамшуулалтай давхардуулан олгосон байна	1	10,828.0	0	0	1	10,828.0	0	0	0	0	0	0	0
	1	10,828.0	0	0	1	10,828.0	0	0	0	0	0	0	0

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
							0.0	0.0
Дүн	0.00	0.00	0.0	0.0	0.00	0.00	0.0	0
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн	0.0	0.0	0	0.0	0.0	0.0	0.0	0
Нийт дүн	0	0	0	0	0	0	0.0	0

**5. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	<b>НИЙТ</b>	<b>1</b>	<b>1</b>			<b>1</b>			

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
2026 оны 02 дугаар сарын 25